"Хөдөлмөр засал" хөтөлбөрийн чанар хүртээмжийн үнэлгээ

С.Булганчимэг[1], М.Эрдэнэцэцэг[1], С.Долгорсүрэн[1]
Б.Мөнхбаясгалан[1], С.Оюун-Эрдэнэ[1], Б.Солонго[2], Б.Оюунгоо[1]
АШУҮИС-ийн Сувилахуйн Сургууль[1],
АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургууль[2]
bulganchimeg.s@mnums.edu.mn

Түлхүүр үг
Хөтөлбөрийн үнэлгээ, Хөдөлмөр засал, Хөдөлмөр засалч, нөхцөл байдал, орц, явц, гарц

Товч утга
Сэргээн засах салбарын нэн чухал, эрэлттэй байгаа мэргэжилтэн бол хөдөлмөр засалч юм. Мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрт үнэлгээ хийх нь сургалтын хөтөлбөрөө хэрхэн сайжруулах талаар хөтөлбөрөөс авч байгаа мэдээлэл бөгөөд оюутан, төгсөгч, багш нар болон бусад оролцогч талуудын хөтөлбөрийн тухай үнэлгээ, санал хүсэлт нь хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотой байдаг. Судалгааны зорилго: "Хөдөлмөр засалч" мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрөөр суралцаж буй оюутан болон төгсөгчид хөдөлмөр заслын сургалтын хөтөлбөрийн чанар хүртээмжийг хэрхэн үнэлж буйг тодорхойлох. Агшингийн судалгааны загварыг ашиглаж тоон судалгааны аргаар хийсэн ба судалгаанд тус хөтөлбөрийн 34 оюутан, 19 хөдөлмөр засалч, нийт 53 хүн хамрагдсан. Судалгааг хөтөлбөрийн үнэлгээний батлагдсан загвар болох CIPP-г ашигласан бөгөөд асуумжийн дүнг дүрслэх болон дүгнэх статистикийн аргаар боловсруулав. Судалгаанд оролцогчдын өгсөн дүгнэлтийг асуумжийн 4 бүлгээр задалж үзвэл сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал 4.04±0.6, сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн, орчин 2.96±0.79; сургалтын үйл явц 4.07±0.59, сургалтын үр дүн 4.08±0.66 байсан ба эдгээр үзүүлэлтүүдийг суралцагчдын дамжаа тус бүрээр харьцуулахад үнэн магадлал бүхий ялгаа харагдахгүй байна ($p>0.01$). Пирсоны корреляцын аргаар үзэхэд сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал нь жил ирэх тусам дээшилж байгаа буюу хүчтэй эерэг хамааралтай ($r=0.95$) байдал ажиглагдлаа. Сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал нь жил ирэх тусам сайжирч байна. "Хөдөлмөр засалч" мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, сургалтын үйл явц, сургалтын үр дүнг суралцагчид хангалттай сайн гэж үзсэн хэдий ч сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн, орчин нь шаардлага бүрэн хангахгүй байна гэж үзэж байна.

Үндэслэл

Хүн амын эрүүл мэндийн ерөнхий хэрэгцээ шаардлага боловсрол, эрүүл мэндийн аль алиных нь хэрэгцээг бий болгодог бөгөөд энэ нь эргээд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ болж хувирдаг. Анагаахын боловсролын үйлчилгээ нь эрүүл мэндийн системд ажиллах мэргэжилтнүүдийн эрэлт хэрэгцээг хангах, боловсон хүчний хангамжийг бий болгодог. Эрүүл мэндийн систем дэх эрэлт, боловсролын системийн мэргэжилтний нийлүүлэлтийн тэнцвэртэй харилцан үйлчлэлцлээр хөдөлмөрийн зах зээл дээрх эрүүл мэндийн мэргэжилтний хүний нөөцийг зөв тодорхойлдог[1]. ДЭМБ "Тогтвортой хөгжлийн зорилт"-ыг "Эрүүл амьдралыг хангах, бүх насны хүмүүсийн сайн сайхан байдлыг дэмжин урагшлуулах" хэмээн тодорхойлсон. Мөн Швейцарийн Женев хотноо 2017 онд зохион байгуулагдсан "Сэргээн засах 2030-Үйл ажиллагааны уриалга" чуулга уулзалтаас сэргээн засах тусламжийг 21-р зууны эрүүл мэндийн гол түлхүүр болно хэмээн үзсэн байна. Үүний нэг төлөөлөл болох сэргээн засах салбарын нэн чухал, эрэлттэй байгаа мэргэжилтэн бол хөдөлмөр засалч юм[2]. АШУҮИС-ийн хувьд Хөдөлмөр засалч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш

үнэлгээ хийж байгаагүй бөгөөд тус хөтөлбөрийг Хөдөлмөр Заслын Дэлхийн Холбооноос гаргасан стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх эхний алхам юм[3]. Мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрт үнэлгээ хийх нь сургалтын хөтөлбөрөө хэрхэн сайжруулах талаар хөтөлбөрөөс авч байгаа мэдээлэл[4] бөгөөд оюутан, төгсөгч, багш нар болон бусад оролцогч талуудын хөтөлбөрийн тухай үнэлгээ, санал хүсэлт нь хөтөлбөрийн чанарыг сайжруулахтай холбоотой байдаг[4-6].


Зорилго, зорилт

Хөдөлмөр засалч" мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрөөр суралцаж буй оюутан болон төгсөгчид хөдөлмөр заслын сургалтын хөтөлбөрийн чанар хүртээмжийг хэрхэн үнэлж буйг тодорхойлох

1. "Хөдөлмөр засал" хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудаас авсан асуумжаар хөтөлбөрийн тухай үнэлгээ хийх
2. "Хөдөлмөр засал" хөтөлбөрөөр суралцаж төгссөн хөдөлмөр засалчдаас авсан асуумжаар хөтөлбөрийн тухай үнэлгээ хийх

Арга аргачлал

Агшингийн судалгааны загварыг ашиглаж тоон судалгааны аргаар хийсэн ба судалгаанд "Хөдөлмөр засалч" мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрөөр суралцаж буй 34 оюутан, тус хөтөлбөрөөр сурч төгссөн 19 хөдөлмөр засалч, нийт 53 хүн хамрагдсан. Судалгаанд хамруулахад энэ хөтөлбөрөөр сурч байгаа болон суралцаж төгссөн, сайн дураар судалгаанд оролцохыг зөвшөөрсөн, мэргэжлээрээ ажиллаж байгаа зэрэг шалгуурыг ашиглалаа. Судалгааг авахдаа Стаблибиэм (2007) нарын боловсруулсан сургалтын хөтөлбөрийн үнэлгээний батлагдсан загвар болох CIPP[7]-г ашигласан.



Зураг 1. CIPP загвар

Тус загвар нь С-Нөхцөл байдал, I-Орц, Р-Явц ба Р-Гарц гэсэн дөрвөн бүлэг бүхий Ликерт хэлбэрийн үнэлгээний асуумж бөгөөд нөхцөл байдал (context) гэсэн бүлэгт хөтөлбөрийн алсын хараа, зорилго, зорилт нь хоорондын болон сургуулийн алсын хараа, зорилготой уялдаж байгаа эсэх, хөтөлбөрийн зорилго нийгмийн хэрэгцээнд хүрч байгаа эсэхийг тодорхойлоно. Орц (Input) бүлэгт хөтөлбөрийн зорилгыг хангахад ашигласан нөөцийг тодорхойлох мэдээллүүд, чанарыг үнэлэх цаг хугацаа, хүний нөөц, биет нөөц, хэрэглэгдэхүүн, дэд бүтэц, сургалтын хөтөлбөр, агуулга зэрэг орно. Явц (Process) бүлэгт хөтөлбөрийн зорилгод хүрэхэд заахуй, суралцахуйн явцын онцлог, арга зүй, үнэлгээ, сургуулийн бусад үйл ажиллагааг хамаарна. Гарц (Product) бүлэгт хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд чиглэн, сурлагын амжилтаас илүү хөтөлбөрөөр эзэмшсэн чадамжуудыг амьдрал дээр хэрэглэж чаддаг эсэхээр тус тус тодорхойлно.[8]

Хүснэгт 1. CIPP загвар, асуумжийн бүлэг тус бүрийн асуултууд

Нэр	Ерөнхий	Нөхцөл байдал (Context)	Орц (Input)	Явц (Process)	Гарц (Product)	Хагас нээлттэй	Нээлттэй	Нийт
Оюутан	1-3	4-7	8-22	23-40	41-47	-	1	51
Төгсөгч	1-5	4-7	8-16	17-32	33-52	2	1	58

Оюутнуудаас 50 асуулт, төгсөгчдөөс 56 асуултыг 1 (огт санал нийцэхгүй)-ээс 5 (бүрэн нийцнэ) хүртэл оноогоор Google form ашиглан авсан. Асуумжийн бүлэг тус бүрийн дотоод найдвартай байдлыг Кронбах альфагаар шалгахад $0,9>\alpha\geq0,8$ байлаа. Статистик боловсруулалтын SPSS 21 программ ашиглан дүнг дүрслэх болон дүгнэх статистикийн аргаар боловсруулав.

Үр дүн

Судалгаанд тус хөтөлбөрөөр төгссөн болон сурч байгаа хүмүүс 100 хувь хамрагдсан ба хүснэгт 2-д ерөнхий мэдээллийн үзүүлэлтүүдийг оруулаа.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

	Бүлэг		Нас		Хүйс	
	Дамжаа/ Төгсөлт N	(%)	Насны бүлэг	(%)	Хүйс	Тоо (%)
Оюутан	I (8)	24,3%	18 хүртэл	5,7	Эмэгтэй	97,1%
	II (9)	27,2%	19-20	2,9%		
	III (4)	11,4%	21-23	34,3%	Эрэгтэй	2,9%
	IV (13)	37.1%	≥23	28,6%		
Төгсөгч	2020 (4)	21,1%	20-25	100%	Эрэгтэй	10,5%
	2019 (10)	52,6%				
	2018 (5)	26,3%			Эмэгтэй	89,4%

Судалгаанд хамрагдсан нийт 53 хүний хариултыг CIPP-гийн бүлэг тус бүрээр задлан авч үзвэл сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал 4,04±0,6 оноо, сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн, орчин 2,96±0,79 оноо, сургалтын үйл явц 4,07±0,59 оноо, сургалтын үр дүн 4,08±0,66 оноо байсан ба эндээс үзэхэд судалгаанд оролцогчид сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, сургалтын үйл явц, сургалтын үр дүн гэсэн үзүүлэлтэнд сэтгэл ханамжтай байна. Харин сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн, орчин гэсэн үзүүлэлтэнд сэтгэл дундуур байгаа нь харагдаж байна. Тиймээс энэхүү бүлгийг задалж харвал нийт оролцогчдын 69,8% нь сургалтын орчин тохилог, 84,9% нь мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ хангалттай, 75,5% нь ур чадварын хичээлийн өрөө тасалгаа хүрэлцээ сайн гэсэн асуултуудад огт нийцэхгүй, нийцэхгүй, мэдэхгүй буюу 1,2,3 гэсэн хариулт өгсөн байгаа нь сургалтын орчин нөхцөл хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчид болон асуумжийн дундаж үзүүлэлт

	Дамжаа/ Төгсөлт	Нөхцөл байдал (Context)	Орц (Input)	Явц (Process)	Гарц (Product)
		M,St.Dev			
Оюутан	I	4,5±0,5	3,6±0,7	4,05±0,4	4,45±0,5
	II	4,44±0,5	3,8±0,7	4,42±0,4	4,5±0,5
	III	4,08±0,4	2,09±0,37	3,5±0,68	3,6±0,8
	IV	4,08±0,47	2,62±0,53	3,72±0,57	3,67±0,79
Дундаж		4,26±0,5	2,91±0,8	4,06±0,65	4,06±0,79
Төгсөгч	2020	3,94±0,1	3,19±0,44	4,07±0,33	3,93±0,20
	2019	3,53±0,85	2,96±0,94	4,04±0,55	4,18±0,39
	2018	3,65±0,6	3,08±0,5	4,18±0,25	4,08±0,25
Дундаж		3,64±0,7	3,04±0,76	4,08±0,45	4,1±0,34
Нийт дундаж		4,04±0,6	2,96±0,79	4,07±0,59	4,08±0,66

Оюутны үзүүлэлтүүдийг суралцагчдын дамжаа тус бүрээр харьцуулахад сургалтын нөөц хэрэглэгдэхүүн бүлгээс бусад бүлэгт үнэн магадлал бүхий ялгаа харагдахгүй байна ($p>0.01$). Энэ үзүүлэлтээс харахад оюутнууд сургалтынхаа хөтөлбөрт ерөнхийдөө сэтгэл ханамжтай байгаа хэдий ч 3 болон 4-р дамжааны оюутнууд сургалтын нөөц хэрэглэгдэхүүн орчинд сэтгэл ханамжгүй байгаа нь харагдаж байна. Харин төгсөгчдийн дундаж үзүүлэлтээс харахад төгсөгчид сургалтын хөтөлбөртөө ерөнхийдөө сэтгэл хангалуун байна.

Судалгаанд оролцогчдыг одоо суралцаж буй оюутнууд болон төгсөгчид гэж хоёр бүлэг болгон хуваж тэдний хариултыг харьцуулахын тулд Хараат бус түүврийн t-тестийг ашиглалаа. Статистик боловсруулалтын дүнгээс харахад ач холбогдлын түвшин сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал 0.003, орчин 0.573, үйл явц 0.876, үр дүн 0.814 байлаа. Энэ нь суралцагчид болон төгсөгчдийн хувьд зөвхөн сургалтын нөхцөл байдал бүлэгт ялгаа ажиглагдаж бусад бүлэгт ялгаагүй гэдэг нь харагдаж байна.

Хүснэгт 4. Сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, орчин, үйл явц, үр дүнд жилийн хамаарал

Correlations

		Жил	Сургалтын нөхцөл байдал	Сургалтын нөөц хэрэглэгдэхүүн, орчин	Сургалтын үйл явц	Сургалтын үр дүн
Жил	Pearson Correlation	1	.955**	.113	.237	.375
	Sig. (2-tailed)		.001	.809	.609	.407
	N	7	7	7	7	7
Сургалтын нөхцөл байдал	Pearson Correlation	.955**	1	.307	.403	.466
	Sig. (2-tailed)	.001		.503	.370	.292
	N	7	7	7	7	7
Сургалтын нөөц хэрэглэгдэхүүн, орчин	Pearson Correlation	.113	.307	1	.931**	.833*
	Sig. (2-tailed)	.809	.503		.002	.020
	N	7	7	7	7	7
Сургалтын үйл явц	Pearson Correlation	.237	.403	.931**	1	.953**
	Sig. (2-tailed)	.609	.370	.002		.001
	N	7	7	7	7	7
Сургалтын үр дүн	Pearson Correlation	.375	.466	.833*	.953**	1
	Sig. (2-tailed)	.407	.292	.020	.001	
	N	7	7	7	7	7

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).

Сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, орчин, үйл явц, үр дүнгийн байдал жил ирэх тусам хэрхэн өөрчлөгдөж байгааг Пирсоны корреляцын аргаар үзэхэд хүчтэй эерэг хамааралтай ($r=0.95$) буюу сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал нь жил ирэх тусам дээшилж байгаа байдал ажиглагдлаа.

Хэлцэмж

Анагаах ухааны боловсрол судлалын чиглэлээр Монгол улсад олон тооны судалгаа шинжилгээний ажлуудыг хийсэн байдаг. Үүнээс судлаач Д.Отгонбаярын нарын судалгаанд сургалтын хөтөлбөрт үнэлгээ өгөхдөө Киркпатрикийн үнэлгээний эхний 3 үе шатыг ашигласан байна. Судалгааны үр дүнд Ликертийн хэмжүүрээр анагаахын суралцагсдын сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлоход дундаж түвшинд (3.41), төгсөгчдийн 94.1% нь сургалтын нэгдмэл хөтөлбөрт дундаас дээш хангалттай үнэлгээ өгсөн байна[9]. Судлаач Баясгаланмөнх нарын судалгаанд АШУҮИС-ийн бүрэлдэхүүн нэг, салбар гурван сургуульд эх баригч бэлтгэж буй хөтөлбөрийг Киркпатрикийн үнэлгээний эхний 3 үе шатыг ашиглан үнэлсэн бөгөөд хөтөлбөрөөр суралцаж байгаа 464 оюутнаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд сургалтын үйл ажиллагаа 3.99±0.48, сургалтын орчин 3.20±0.87, оюутны үйл ажиллагаа 3.59±0.62, дундаж сэтгэл ханамж дунджаас дээгүүр (3.73) үнэлгээ өгсөн байна. Төгсөгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий түвшин 3.93±0.51 буюу дунджаас дээгүүр

түвшинд байсан ба сургалтын үйл ажиллагаа сайн байсан гэдэгт 4.26±0.77, доод оноо нь сургалтын орчин материаллаг бааз хангалттай байсан уу? гэдэгт 3.47±1.10 байлаа[10]. Эдгээр судалгааны үзүүлэлтүүдээс оюутан, төгсөгчдийн хувьд сургалтын орчин, материаллаг бааз зэрэгт доод оноо өгсөн байгаа нь манай судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Харин бусад үзүүлэлтүүд сургалтын үйл ажиллагаа, оюутны үйл ажиллагаанд хангалттай гэж үнэлсэн байна. Хайти улсын Faculte des Sciences de Rehabilitation de Leogane (FSRL) сургуульд шинээр хэрэгжүүлж буй хөдөлгөөн засалч болон хөдөлмөр засалч бэлтгэх хөтөлбөрийг CIPP загварыг ашиглан үнэлэхэд сургалтын үйл явцад илүү эмнэл зүйд чиглэсэн сургалтууд шаардлагатай байна гэж суралцагчид нь үзжээ[4] Харин Д.Отгонбаяр нар анагаахын хөтөлбөрийг, Б.Баясгаланмөнх нар эх барихуйн хөтөлбөрийг Киркпатрикийн үнэлгээний аргаар үнэлсэн байлаа.

Дүгнэлт

Сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал нь жил ирэх тусам сайжирч байна. "Хөдөлмөр засалч" мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, сургалтын үйл явц, сургалтын үр дүнг суралцагчид хангалттай сайн гэж үзсэн хэдий ч сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн, орчин нь шаардлага бүрэн хангахгүй байна гэж үзэж байна. Тиймээс сургуулийн орчин нөхцлийг сайжруулж, мэргэжлийн ном сурах бичгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Шинээр боловсруулан хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт анх удаа үнэлгээ өгч, дүгнэлт хийж байгаагаараа энэхүү судалгаа нь шинэлэг боловч сургалтын хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй тул судалгаанд оролцогч төгсөгч, оюутны тоо цөөн байлаа. Цаашид тус хөтөлбөрөө нарийвчлан үнэлэхийн тулд бусад оролцогч талууд болох багш, удирдлага, шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогч, ажил олгогч, үйлчлүүлэгчдийг оролцуулан тоо, чанарын судалгаа авах шаардлагатай байна.

Талархал

Судалгааны ажилд хамтран оролцсон АШУҮИС-ийн СС-ийн ББСТ-ийн багш М.Эрдэнэцэцэг, Хөдөлмөр заслын 4-р дамжааны оюутан Б.Мөнхбаясгалан, С.Оюун-Эрдэнэ нартаа талархлаа илэрхийлье.

Ном зүй

1. *Frenk J, Chen L, Bhutta ZA, et al. Health professionals for a new century: transforming education to strengthen health systems in an interdependent world. The lancet. 2010;376(9756):1923-1958.*
2. *Wagman P, Johansson A, Jansson I, et al. Making sustainability in occupational therapy visible by relating to the Agenda 2030 goals—A case description of a Swedish university. World Federation of Occupational Therapists Bulletin. 2020;76(1):7-14.*
3. *https://www.wfot.org/resources/new-minimum-standards-for-the-education-of-occupational-therapists-2016-e-copy.*
4. *Honorat D. Curriculum Evaluation of FSRL: An Occupational Therapy Program in Haiti. 2018.*
5. *Baptiste SE, Dhillon S, Decker K, et al. The Occupational Therapy Examination and Practice Preparation (OTepp) Program: Development, Implementation and Evaluation of an Educational Program for Internationally-Educated Occupational Therapists. Journal of Occupational Therapy Education. 2020;4(3):14.*
6. *Carnell B, Fung D. Developing the higher education curriculum: Research-based education in practice. UCL Press; 2017.*
7. *Aziz S, Mahmood M, Rehman Z. Implementation of CIPP model for quality evaluation at school level: A case study. Journal of Education and Educational Development. 2018;5(1):189-206.*
8. *Moore SE, Logerwell E, Eisner L, et al. Marine fishes, birds and mammals as sentinels of ecosystem variability and reorganization in the Pacific Arctic region. The Pacific arctic region: Springer; 2014:337-392.*
9. *Отгонбаяр Д. Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд. Улаанбаатар: Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 2010.*
10. *Баясгаланмөнх Б. Үр дүнд суурилсан эх барихуйн сургалтын загвар. Улаанбаатар: Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль; 2016.*

Evaluation of the quality and accessibility of the "Occupational therapy" curriculum

Bulganchimeg.S[1], Erdenetsetseg.M[1], Dolgorsuren.S[1]
Munkhbayasgalan.B[1], Oyunerdene.S[1], Solongo.B[2], Oyungoo.B[1]
School of Nursing, MNUMS[1]
School of Medicine, MNUMS[2]
bulganchimeg.s@mnums.edu.mn

ABSTRACT

Introduction: The most important and in-demand specialist in the field of rehabilitation is the occupational therapist. Evaluation of the curriculum provides information on how to improve the curriculum and evaluation of the program by students, alumni, faculty and other stakeholders is related to improving the quality of the program. Purpose: To determine how students and alumni of the "Occupational Therapist" training program evaluate the quality and accessibility of the occupational therapy program. Method: Quantitative research was conducted using the cross-sectional research design and the study involved 34 students, 19 occupational therapists, and a total of 53 people. The survey was conducted using the CIPP, an approved program evaluation model, and the results of the questionnaire were analyzed using descriptive and inferential statistics. Results: The average response of participants in each 4 groups of questionnaires are as follows: the context is 4.04 ± 0.6; input, materials and environment is 2.96 ± 0.79; process is 4.07 ± 0.59; and product is 4.08 ± 0.66, and there was no significant difference in these values for each student's groups ($p > 0.01$). Pearson's correlation shows a strong positive correlation ($r = 0.95$) in the context of learning activities which indicates the improvement from year to year. Conclusion: The context of the training activities is improving year by year. Although the input, process, and product of the "Occupational Therapist" training program were considered good enough by the students, the training resources, materials, and environment did not fully meet the requirements.